



МОНГОЛЫН ШАТРЫН ХОЛБОО

2011 ОНЫ ӨСВӨРИЙН ДАШТ-Д ОРОЛЦОХ БАГ, ТАМИРЧДЫН ЖУРАМ

1. Зорилго

1.1 2011 оны 9-р сарын 17-27-ны өдрүүдэд Бразили улсын Калдас Новас хотноо зохион байгуулагдах Өсвөрийн ДАШТ-д оролцох баг, тамирчдыг өндөр зохион байгуулалттай, амжилттай оролцуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Тэмцээнд оролцох баг бүрэлдэхүүн

2.1 Тус тэмцээнд оролцох баг бүрэлдэхүүний нэрс болон багийн ахлагчийг МоШХ 2011 оны 9-р сарын 2-ний өдөр тушаалаар батлана.

2.2 Өсвөрийн ДАШТ Зохион Байгуулах Хорооны журмын дагуу ангилал тус бүрт (8 нас хүртэл, 9-10 нас, 11-12 нас, 13-14 нас, 15-16 нас, 17-18 нас) нэг тамирчны байр хоолны зардалыг бүрэн хариуцна.

2.3 МоШХ нь 2011 оны Өсвөрийн УАШТ-ний дүнг үндэслэн ангилал тус бүрт алтан медаль авсан тамирчдыг 2.2 заалтанд заасан эрхийг олгоно. Тухайн тамирчныг **Үндсэн тамирчин** гэнэ.

2.4 Тухайн тамирчин МоШХ-нд тэмцээнд оролцох мэдээллийг 2.1-р заалтанд заасан хугацаанд өгөөгүй тохиолдолд II, III байр эзэлсэн тамирчинд эрхийг шилжүүлнэ.

2.5 Өсвөрийн УАШТ-ний I-III байрны тамирчид МоШХ-нд тэмцээнд оролцох мэдээллийг 2.1-р заалтанд заасан хугацаанд өгөөгүй тохиолдолд тухайн насны ангилалд оролцох тамирчныг МоШХ комисс хуралдуулж томилно.

2.6 Өсвөрийн ДАШТ-д оролцох нэмэлт тамирчид, дагалдан явах хүмүүс МоШХ-д 2011 оны 9-р сарын 1-ний дотор бүртгүүлнэ.

2.7 МоШХ-ны тушаалаар батлагдсан баг бүрэлдэхүүний нэрсийг багийн ахлагч Өсвөрийн ДАШТ Зохион Байгуулах Хороо руу 2011 оны 9-р сарын 5-ны өдөр явуулна.

3. Бүртгүүлэхэд шаардагдах бичиг баримт болон төлбөр

3.1 Тус тэмцээнд оролцоход шаардагдах бичиг баримт болон төлбөрийг 2011 оны 9-р сарын 1-ний дотор МоШХ-нд тушаана.

3.2 Шаардагдах бичиг баримт:

3.2.1 Иргэний үнэмлэх, Төрсний гэрчилгээний хуулбар

3.2.2 Гадаад паспортны хуулбар

3.2.3 2x3 хэмжээтэй зураг 4 ширхэг

3.3 Төлбөр:

3.3.1 ФИДЕ-д төлөх төлбөр:

• Үндсэн тоглогч 70 евро

• Нэмэлт тоглогч 140 евро

3.3.2 Зохион байгуулах хороонд төлөх төлбөр.

• Үндсэн тоглогч 100 евро

• Нэмэлт тоглогч 100 евро

• Дагалдан явагч 100 евро

3.4 Төлбөрийг МоШХ-нд төлнө.

3.5 Төлбөр дээр гуйвуулгын мөнгө нэмэгдэнэ.

3.6 Нэмэлт тоглогч нь Зохион Байгуулах Хорооны заасан зочид буудалд байрлана.

3.7 Нэмэлт тоглогч нь 10 өдрийн байрлах төлбөрийг төлөх шаардлагатай.

3.8 Журмын дагуу заагдсан хугацаанд бичиг баримт бүрдүүлээгүй болон төлбөр төлөөгүй тохиолдолд баг бүрэлдэхүүнд оруулахгүй.

4. Бусад

4.1 Виз болон онгоцны тийзийн асуудлыг баг бүрэлдэхүүн бүрэн бүрдэсний дараа багийн ахлагч хариуцна.

5. Комисс

- МоШХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Баатар / 99094303
- ФИДЕ төлөөлөгч Г.Алтан-Оч
- МоШХ-ны менежер Ц.Батсайхан / 99009572

6. Холбоо барих

- Цахим шуудангийн хаяг: mglchess_secretary@yahoo.com monchess@yahoo.com
- Өсвөрийн ДАШТ-н албан ёсны цахим хаяг: www.wycc2011.com
- Зохион Байгуулах Хорооны журмын холбоос: www.wycc2011.com/en/regulations/genreg.html